MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Шалтгаан - үр дагаврын шинжилгээ

Мишэл Филион, Төрийн удирдлагын зөвлөх

Агуулга

- Дүн шинжилгээ
- Шалтгаант холбоо хамаарал
- Шийдвэр гаргах арга хэрэгслүүд
- Оролцоог хангах үйл явц
- Зорилт-үр дүнгийн модыг өөрчлөн ашиглах боломж
- Логик бүдүүвч ба үр дүнгийн гинжин хэлхээний хоорондын уялдаа

mfilion@ign.quebec

Дүн шинжилгээ

Өгөгдөл эсвэл мэдээллийн харилцан хамаарлыг тодорхойлохын тулд түүнийг бүрдэл хэсгүүдэд нь задлаж, системтэйгээр судалж үнэлэх үйл явц юм.

Шалтгаан-үр дагаврын холбоо хамаарлыг илрүүлж, ойлгохын тулд өгөгдөл, баримтыг шинжлэн үздэг. Ингэснээр асуудлыг шийдвэрлэж, шийдвэр гаргах үндэс суурь болж өгдөг.

mfilion@ign.quebec

Шалтгаант холбоо хамаарал

- Учир шалтгааны холбоо гэдэг бол аливаа шалтгаан ба үр дагаврын хоорондох холбоо хамаарал юм.
- Шалтгаан ба үр дагаврын хоорондох энгийн холбоо хамаарал нь шугаман бөгөөд нэг чиглэлтэй байдаг.
- Харин байгууллагыг систем хэмээн авч үзэж байгаа үед шалтгаан үр дагаврын хоорондох холбоо хамаарал нь илүү нарийн төвөгтэй болж, мөчлөг хэлбэрийн шалтгаант холбоо, харилцан бие биенээсээ хамаардаг системүүд, шугаман бус хэлбэртэй болдог.

mfilion@ign.quebec

Шугаман бус хамаарал

- Шалтгаан-үр дагаврын хоорондох маш нарийн төвөгтэй холбоо хамаарлын улмаас нэг хувьсагч нь нөгөөдөө тодорхой харьцаагүйгээр нөлөөлж байх үед шугаман бус хамаарал оршин байдаг.
- Шугаман бус хамааралтай үед шалтгаан-үр дагавар гэж юуг илэрхийлж буй нь тодорхойгүй болж, шалтгаан-үр дагаврын хоорондох холбоо хамаарал нь хугацаа, орон зай нэмэгдэхийн хэрээр илүү бүрхэг болж, тухайн холбоо хамаарлыг практикт ашиглах боломжгүй болдог.

mfilion@ign.quebec

Корреляци харилцан хамаарал

- Хоёр эсвэл түүнээс олон зүйлсийн хоорондох харилцан хамаарлын хүч буюу чиглэлийг илэрхийлэх ойлголт юм.
- Заавал учир шалтгааны холбоо оршин байх албагүй.

Шийдвэр гаргах арга хэрэгслүүд

- Шийдвэрийн матриц;
- Шийдвэрийн мод;
- Паретогийн шинжилгээ;
- Зардал-үр ашгийн шинжилгээ (ЗҮАШ);
- SWOT (давуу ба сул тал, боломж аюулыг үнэлэх) буюу нөхцөл байдлын шинжилгээний арга;
- PEST буюу макро орчны (улс төр, эдийн засгийн, нийгмийн, технологийн) шинжилгээний арга.

mfilion@ign.quebec

Асуудлын мод

- Энэ бол шийдвэр гаргахад ашигладаг модтой ижил харагддаг аргачлал юм.
- Асуудлын мод бол гол гол асуудлыг шалтгаан, үр дагаврынх нь хамтаар зураглах нэг арга зам бөгөөд төсөл төсөв төлөвлөгчдөд тодорхой, удирдаж болохуйц зорилт тодорхойлоход нь тусладаг.
- Бусад модны адил асуудлын мод нь гурван хэсэгтэй. Үүнд: их бие, үндэс, мөчрүүд.
- Модны их бие бол шийдвэрлэхийг зорьж буй гол асуудал юм.

mfilion@ign.quebec

Загасны ясан диаграм

- Энэ бол шийдвэрийн мод. Ийнхүү нэрлэсэн шалтгаан нь загасны араг яс шиг харагддагаас нь болжээ.
- Мөн “шалтгаан-үр дагаврын диаграм” эсвэл “ишикава диаграм” ч гэж нэрлэгддэг загасны ясан диаграм нь аливаа нэг асуудлын цаад шалтгааныг тогтоохын тулд цаад шалтгаануудыг нь ангилан харуулах арга хэрэгсэл юм.

mfilion@ign.quebec

Төрийн үйлчилгээнд жендэрийн зөрүүтэй байдал үүсгэдэг энгийн шалтгаанууд

- Төрийн үйлчилгээ үзүүлж буй албан хаагч болон авч буй ард иргэдийн мөн, чанар ба үйлчилгээний чанар (төрийн үйлчилгээг үзүүлж буй байдал)
- Үзүүлж буй үйлчилгээг авахад хэр хүндрэлтэй байдал (хүртээмж)
- Тухайн үйлчилгээг авахад гарах зардал, санхүүгийн чадвар (зардал)
- Үйлчилгээ авахад саад учруулж буй нийгмийн бусад үүргүүд (хүйсийн гүйцэтгэдэг үүрэг)
- Эмэгтэйчүүд төрийн үйлчилгээ авахад саад болдог нийгэмд тогтсон хэм хэмжээ, үзэл санаа (хэм хэмжээ)
- Эмэгтэйчүүд үйлчилгээ авахад саад болдог соёл (соёлын хүчин зүйл).

mfilion@ign.quebec

Оролцоог хангах арга замууд

Шийдвэрийн мод нь олон оролцоог хангах арга замуудыг санал болгодог.

Хамгийн хялбархан арга нь оролцогч талууд, түншлэгчид, шууд үр шим хүртэгчид болон орхигдсон хүмүүстэй уулзаж, зөвлөлдөх явдал юм.

mfilion@ign.quebec

Асуудлын модыг зорилгын мод болгох

Асуудлын мод эсвэл загасны ясан диаграмыг гаргах явцад тогтоосон асуудал, шалтгааны оронд нэг хувилбар эсвэл шийдлийн олон хувилбарыг бичих замаар амархан “зорилгын буюу шийдвэр шийдлийн мод” болгон хувиргаж болно.

Зорилгын модыг логик бүдүүвч болгох

Зорилгын мод нь Логик бүдүүвчийн эхний багана болж өгдөг.

mfilion@ign.quebec

Үр дүнгийн гинжин хэлхээ

Логик бүдүүвчийн эхний багана нь аливаа төслийн “үр дүнгийн гинжин хэлхээ” болдог.

Бичил төслийн хувилбар боловсруулах арга

Шийдвэрийн модыг ашигласнаар Ишикава диаграмын баруун талд голлон анхаарах замаар одоогоор мэдэгдэж буй шалтгааныг оновчтой шинжлэн үздэг. Энэ нь бичил төсөл боловсруулах хялбар арга зам бөгөөд эрх тэгш байдал, тэгш эрхийг сайжруулах баталгаатай арга хэмжээ юм.

mfilion@ign.quebec



Merci.